

ПРОФЕССОР Д.ЧҮЛТЭМИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Зорилго

ШУГЗ, Профессор Д.Чүлтэмийн нэрэмжит тэтгэлэг (цаашид нэрэмжит тэтгэлэг гэнэ) нь дараах үндсэн хоёр зорилготой. Үүнд:

1.1 Монгол Улсад цөмийн физик, технологийн судалгааны салбарыг үндэслэгчдийн нэг, Монгол Улсын цөмийн физикийн шинжлэх ухааны анхны доктор, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, профессор Даржаагийн Чүлтэмийн алдрыг мөнхжүүлэх;

1.2 Цөмийн физик, технологийн чиглэлээр болон энэ чиглэлтэй холбоотой судалгаа хийж МУИС-д суралцаж буй бакалавр, магистрын түвшний суралцагч оюутнуудын билэг авьяас, ур чадвар, идэвх чармайлтыг дэмжих, өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

Хоёр. Нэрэмжит тэтгэлэг олгох нөхцөл

Дараах нөхцөлийг хангасан суралцагчдад нэрэмжит тэтгэлгийг олгоно. Үүнд:

2.1 МУИС-ийн бакалаврын болон магистрын түвшний идэвхтэй төлвийн амжилттай суралцаж байгаа суралцагч байх;

2.2 Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд идэвхтэй оролцдог; хурал семинарт илтгэл тавьж хэлэлцүүлсэн; судалгааны багт харьяалагддаг; цөмийн физик, технологийн салбартай холбоотой нийгмийн болон байгалийн ухааны судалгааны ажил хийж байгаа; цөмийн инженерчлэлийн хөтөлбөрөөр суралцаж буй; багаж, тоног төхөөрөмж зохион бүтээхэд оролцсон зэрэг бол давуу тал болно.

Гурав. Бүрдүүлэх материал

3.1 Маягтын дагуу бөглөсөн нэрэмжит тэтгэлэгт хамрагдах хүсэлт /1 хувь/;

3.2 Дүнгийн мэдээлэл буюу дүнгийн тодорхойлолтын эх хувь /1 хувь/;

3.3 Иргэний үнэмлэхний хуулбар /1 хувь/;

3.4 Эрдэм шинжилгээ, нийгмийн үйл ажиллагаанд оролцсон, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн, хуралд илтгэсэн бол тэдгээрийг гэрчлэх баримтын хуулбар. Мөн ямар нэг төрлийн спортын зэрэгтэй бол түүнийг гэрчлэх баримтын хуулбар /тус бүр 1 хувь/.

Дөрөв. Нэрэмжит тэтгэлэг олголт

4.1 Нэрэмжит тэтгэлгийг зарлах, хамрагдах хүсэлтэй суралцагчдын материалыг хүлээн авах, цугласан материалыг төвийн захиргаанд ирүүлэх, сонгон шалгаруулалт хийх, батламж, мөнгөн тэтгэлгийг олгох зэрэг үйл ажиллагааг тухайн хичээлийн жилийн намрын улиралд багтаан хэрэгжүүлж дуусгасан байна.

4.2 Нэрэмжит тэтгэлгийн зарлал, сурталчилгааг төвийн болон МУИС-ийн цахим хуудсуудаар, мөн анонс хэлбэрээр түгээнэ. Тэтгэлгийн материалыг хүлээн авах хугацаа багадаа 14 хоног байна.

4.3 Нэрэмжит тэтгэлэг олгох асуудлыг төвийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

4.4 Нэрэмжит тэтгэлгийг тухайн хичээлийн жилд шилдэг суралцагчид олгоно.

4.5 Нэрэмжит тэтгэлгийн нийт хэмжээ 500,000 төгрөг хүртэл байна.

----oOo-----



Цөмийн физикийн судалгааны төвийн
Захирлын 2020 оны 12 дугаар сарын 18-ний
өдрийн А/09 тоот тушаалын 2.1-р хавсралт

**ПРОФЕССОР Д.ЧҮЛТЭМИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ
ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МАЯГТ***

/Бакалаврын хөтөлбөрийн суралцагчдад зориулсан/

Үндсэн мэдээлэл

- Эцэг /эх/-ийн нэр: _____ Өөрийн нэр: _____
Ургийн овог: _____ Төрсөн он сар өдөр: _____
Хүйс: _____ Үндэс угсаа: _____
- Регистрийн дугаар: _____
- Төрсөн аймаг, хот: _____
- Оршин суугаа хаяг: _____
- Холбоо барих утас: 1. _____ 2. _____
- Цахим шуудангийн хаяг: _____
- Суралцаж буй мэргэжлийн хөтөлбөр: _____
- Суралцаж буй түвшин: _____
- Судалсан багц цаг: _____
- Голч оноо ба голч дүн: _____
- Харилцагч банкны нэр: _____ Дансны нэр: _____ Дансны дугаар: _____
- Нийгмийн идэвх, оролцоог илтгэх мэдээлэл

Сүүлийн 6 сарын дотор
авахуулсан цээж зураг

д/д	Үйл ажиллагааны нэр	Мэдээлэл	Тайлбар

13. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцсон байдал

д/д	Үйл ажиллагааны нэр	Мэдээлэл	Тайлбар

14. Хувийн амжилт, авьяас чадварыг илтгэх мэдээлэл

д/д	Нэр төрөл	Мэдээлэл	тайлбар

15. Шагнал, тэтгэлгийн мэдээлэл

/ Сургууль, дүүрэг, нийслэл, улсын чанартай уралдаан, гадаадын орноос авсан шагнал болон тэтгэлгийг бичнэ/

д/д	Шагналын төрөл	Шагналын нэр	Тайлбар

Маягтыг үнэн зөв бөглөсөн суралцагч: /...../
Гарын үсэг гарын үсгийн тайлал

20 ... оны ... сар ... өдөр

* Маягтыг заавал компьютерээр бөглөнө. Бөглөж өгсөн маягт дахь мэдээллийг зөвхөн энэхүү тэтгэлгийн сонгон шалгаруулалтын зорилгоор хэрэглэнэ.

